“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗАР

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХААРУУЛГА МЭДЭЭЛЭЛ /SAFETY BULLETIN/

2025 оны 10 сарын 15 өдөр № 07/25

ЦАГ АГААРЫН МЭДЭЭНИЙ АНХААРУУЛГА ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Ус цаг уур, орчны мэдээллийн хүрээлэнгийн Цаг агаар, орчны загварчлал, судалгааны хэлтсээс 2025 оны 10 дугаар сараас 12 дугаар саруудын цаг агаарын урьдчилсан төлөвийг тооцоолон гаргасан байна. Энэхүү цаг уурын байгууллагаас гаргасан өвлийн саруудын цаг агаарын мэдээний хувьд агаарын температур олон жилийн дунджаас хүйтэн, хур тунадас их орох төлөвтэй байна. Ялангуяа зүүн аймгуудын нутгаар цаг агаар хүйтэн, хур тунадас харьцангуй их орох төлөв ажиглагдаж байна. Иймд Иргэний нисэхийн ерөнхий газраас 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр ирүүлсэн 02/25 дугаартай байцаагчийн зөвлөмж ирсэнтэй холбогдуулан дараах анхааруулах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Цаг-Уурын ил харааны станц, сансрын антен, глиссадын радио дохиологчийн антен зэрэг цаг-агаарын нөхцөл байдлаас шалтгаалан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй байгууламж, тоног төхөөрөмжийн цасыг цэвэрлэх, мөстөлтөөс хамгаалах бодисыг технологийн дагуу хэрэглэж бэлэн байдлыг хангаж ажиллах.
2. Алслагдсан байгууламжийн ээлж солих, албан томилолтоор ажиллах ажилтнууд замд гарахдаа хувийн бэлтгэлийг сайтар ханган, харьяалах алба нэгжтэйгээ тогтмол холбоо барьж, мэдээллийг өгч ажиллах.
3. Эрчим хүчний хангалтын гэрээ, шуурхай ажиллагааны гэрээний заалтуудын биелэлтэд хяналт тавьж ажиллах, гэрээний хүчинтэй хугацаа дууссан бол сунгуулах.
4. Агаарын шугам, тоног төхөөрөмжийн үзлэгийг хийх. Холболт, тусгаарлагч, газардуулгын бүрэн бүтэн байдлыг шалгах. Конденсац, мөсжилт, хяруу үүсэж богино холболт, газардлага гарахаас сэргийлэх.
5. Төв болон алслагдсан байгууламжуудын нөөц тэжээлийн үүсгүүрүүдийн түлшний нөөцийг бүрдүүлэх. Түлш тос , хөргөлтийн шингэний түвшинг шалгах.
6. Ачаалал шилжүүлэх самбарын ажиллагаанд туршилт,шалгалтыг хийж баталгаажуулах. Контакторуудын блок контакт, завсрын реленүүдийн холболтуудыг шалгаж баталгаажуулах.
7. UPS-ийн ажиллагаа, батарейнуудийн ашиглалтын байдалд хяналт, туршилтыг хийх.
8. Тоног төхөөрөмжийн өрөөний халаагуурын розетка, кабель утас, холболтууд халж байгаа эсэхэд байнгын хяналт хийх.

Утас: 88974030
sqmd@mcaa.gov.mn

9. Орон нутгийн нисэх буудлууд эрчим хүчний ид оргил ачааллын үед агаарын хөлөг буулт, хөөрөлт хийх үед нөөц тэжээл буюу дизель генераторыг 15 минутын өмнө асааж, үндсэн цахилгаан хангамжтай зэрэгцээ ажиллуулан, бэлэн байдлыг ханган ажиллах.
10. Гэрэл суултын систем, PAPI системийн хэлхээний тусгаарлагч трансформаторын холболтуудын худаг мөстөхөөс сэргийлж үзлэгийг хийх. Гэрэл суултын алсын удирдлага, тогтворжуулсан гүйдлийн үүсгүүрийн ажиллагаанд байнгын хяналтыг хийх.
11. Аэродромын цас цэвэрлэгээ, газрын үйлчилгээ, технологийн болон гал унтраах машин механизмуудын өвлийн үйлчилгээг бүрэн хийх, гарааш болон техникийн бэлэн байдлыг хангах.
12. Аэродромын засвар арчлалтын ажлыг тухай бүр хийх, мөс цэвэрлэгээний багаж хэрэгслүүдийг бэлтгэх, онцгой нөхцөл үүссэн үед цас цэвэрлүүлэх гэрээ байгуулах, карбомид, элсний нөөцийг бүрдүүлж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангах.
13. Цаг агаарын тухай сэрэмжлүүлэг, мэдээ, дохиог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад эх сурвалжаас тогтмол авч, холбогдох мэдээллийг цаг алдалгүй дамжуулж, үйлдвэрлэлийн бэлэн байдлыг дээшлүүлэн бусад шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

Утас: 88974030
sqmd@mcaa.gov.mn